



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 09 сарын 16 өдөр

Дугаар А/381

Мөрөн сум

Хөрөнгө зарцуулж, дэмжлэг үзүүлэх
тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2-ын "г", Төсвийн тухай хуулийн 14.2.3, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалын 2.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хорт хавдар өвчнөөр өвдөж хагалгаанд орж, хими эмчилгээнд удаа, дараа орж байгаа Мөрөн сумын иргэн Л.Норовсүрэн, Г.Батбаяр нарт тус бүр 300,000 төгрөг, эм тарианы зардал хүссэн Ч.Болдсайхан, Г.Цэнд-Аюуш, Б.Нэргүй нарт тус бүр 100,000 төгрөг, амьдралын аргагүй байдлыг харгалзан үзэж өрх толгойлсон эмэгтэй П.Жавзандолгор, Ц.Отгонбаяр нарт тус бүр 100,000 төгрөгийн дэмжлэгийг тус тус үзүүлсүгэй.
2. Дээрх 1,100,000 (Нэг сая нэг зуун мянган) төгрөгийг аймгийн Засаг дарга данснаас зарцуулахыг аймгийн Төсвийн ерөнхий нягтлан бодогч (Ц.Мөнхтуяа)-д зөвшөөрсүгэй.
3. Санхүүгийн холбогдох баримтыг бүрдүүлж, хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (С.Нарантуяа)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Л.ГАНБОЛД